

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 70363036 Цахим хаяг: chuluuntsetseg.d@audit.local</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүй	12
3.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө	15
3.5.2 Авлага	15
3.5.3 Бараа материал	16
3.5.4 Үндсэн хөрөнгө	17
3.5.5 Өр төлбөр	18
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо.....	19
3.5.7. Орлогын данс	20
3.5.8. Орлогын данс	21
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	22
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8. Аудитын гол асуудал	24
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	25
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	26
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	27
4. Аудитын илрүүлэлт	28
4.1 Залруулга	29
4.2 Акт	30
4.3 Зөвлөмж	31-32
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	33-36

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,067,382.6	2,040,098.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	769,392.4	1,641,266.9
33	АВЛАГА	180,263.5	206,228.98
35	БАРАА МАТЕРИАЛ	117,726.8	192,602.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,871,612.7	6,636,233.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,871,612.7	6,636,233.2
39200	Биет хөрөнгө	5,803,900.3	6,579,172.7
39300	Биет бус хөрөнгө	67,712.4	57,060.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,938,995.3	8,676,331.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,107.5	8,459.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,107.5	8,459.0
41300	Өглөг	9,107.5	8,459.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,929,887.8	8,667,872.6
51	Засгийн газрын хувь оролцоо	6,929,887.8	8,667,872.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,019,840.1	1,019,840.1
51200	Хуримтлагдсан үр дүн	2,547,972.6	4,285,957.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,362,075.2	3,362,075.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,938,995.3	8,676,331.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,578,698.3	5,536,595.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,376,479.2	1,973,875.2
110	Орлогын албан татвар	26,424.8	44,939.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	26,424.8	44,939.2
113	Хөрөнгийн албан татвар	2,445.0	35,287.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,347,609.4	1,893,648.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,442,278.4	1,361,313.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,442,278.4	1,361,313.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,759,940.8	2,191,478.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,711,718.9	3,354,980.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,711,718.9	3,155,447.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,684,041.4	3,020,859.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,566,263.7	1,608,079.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,901.4	214,602.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,753.5	285,618.9
2104	Хангамж, бараа материалын зардал	68,353.6	74,382.9
2105	Нормативт зардал	100,183.2	200,674.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,990.2	41,624.9
2107	Томилолт, зочны зардал	5,138.8	4,949.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,459.8	37,436.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	382,997.1	553,490.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,027,677.6	134,588.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	199,533.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,866,979.4	2,171,685.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	80,086.6	433,701.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,786,892.8	1,737,984.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,190,464.1	4,541,426.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,376,479.2	1,973,875.2
110	Орлогын албан татвар	26,424.8	44,939.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	26,424.8	44,939.2
113	Хөрөнгийн албан татвар	2,445.0	35,287.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,347,609.4	1,893,648.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,084.1	78,168.5
1181	Газрын төлбөр	40,171.9	109,135.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,267,353.4	1,706,345.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,044.2	370,814.6
120	Нийтлэг татварын бус орлого	54,044.2	370,814.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,759,940.8	2,190,595.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЗЭЭЛИЙН ДҮН	3,359,722.5	2,745,601.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,359,722.5	2,745,601.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,334,065.6	2,610,922.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,561,370.7	1,605,560.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,793.9	214,890.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,753.5	294,618.9
2104	Хангамж, бараа материалын зардал	57,427.8	72,142.0
2105	Нормативт зардал	90,996.8	169,188.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,088.5	40,588.3
2107	Томилолт, зочны зардал	5,138.8	4,949.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,018.7	42,194.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,476.9	166,790.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,025,656.8	134,678.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	830,741.6	1,789,683.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ДҮН	128,814.0	846,809.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,814.0	846,809.2
2200	Дотоод эх үүсвэрээр	128,814.0	846,809.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-128,814.0	-846,809.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-71,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	71,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	701,927.6	871,874.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,464.7	769,392.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	769,392.4	1,641,266.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,220,373.8	5,220,373.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-77,378.8	-77,378.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,142,995.0	5,142,995.0
9	Тайлант үеийн үр дүн	1,786,892.8	1,786,892.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,929,887.8	6,929,887.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,929,887.8	6,929,887.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,929,887.8	6,929,887.8
19	Тайлант үеийн үр дүн	1,737,984.8	1,737,984.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,667,872.6	8,667,872.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Гүйцэтгэл хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,803,698.80	3,327,007.44	476,691.36	87.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,547,699.60	2,543,234.33	4,465.27	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,488,646.90	2,485,528.23	3,118.67	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,616,147.60	1,566,997.51	49,150.09	97.0
210101	Үндсэн цалин	1,107,705.70	1,007,468.15	100,237.55	91.0
210102	Нэмэгдэл	368,539.30	421,874.40	-53,335.10	114.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00	0.0
210104	Урамшуулал	93,890.60	91,642.96	2,247.64	97.6
210105	Гэрээт ажлын хөлс	46,012.00	46,012.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,089.00	210,199.41	4,889.59	97.7
210201	Тэтгэврийн даатгал	151,346.90	148,872.85	2,474.05	98.4

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	15,935.40	15,694.25	241.15	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,748.70	12,368.92	379.78	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,186.90	3,009.49	177.41	94.4
210205	Эрүүл мэндийн даатгал	31,871.10	30,253.90	1,617.20	94.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	316,609.40	294,618.93	21,990.47	93.1
210301	Гэрэл, цахилгаан	39,642.40	23,532.31	16,110.09	59.4
210302	Түлш, халаалт	243,800.40	237,920.62	5,879.78	97.6
210303	Цэвэр, бохир ус	33,166.60	33,166.00	0.60	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,309.10	46,124.06	5,185.04	89.9
210401	Бичиг хэрэг	6,363.50	5,217.90	1,145.60	82.0
210402	Тээвэр, шатахуун	24,512.10	23,672.48	839.62	96.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,608.70	4,861.38	1,747.32	73.6
210404	Ном, хэвлэл	8,785.40	7,284.60	1,500.80	82.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,353.60	1,353.60	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,685.80	3,734.10	-48.30	101.3
2105	Нормативт зардал	89,723.00	70,931.62	18,791.39	79.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,699.30	31,699.30	0.00	100.0
210502	Хоол, хүнс	45,572.70	26,927.52	18,645.19	59.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,451.00	12,304.80	146.20	98.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,875.60	68,667.20	-2,791.60	104.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,569.60	28,199.00	-1,629.40	106.1
210602	Тавилга	6,000.00	6,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	645.40	645.40	0.00	100.0
210604	Урсгал засвар	32,660.60	33,822.80	-1,162.20	103.6
2107	Томилолт, зочны зардал	7,270.00	4,949.10	2,320.90	68.1
210702	Дотоод албан томилолт	7,270.00	4,949.10	2,320.90	68.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,153.20	17,727.27	6,425.93	73.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,125.50	15,511.47	5,614.03	73.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,254.90	1,605.20	649.70	71.2
210803	Даатгалын үйлчилгээ	309.60	309.60	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194.10	173.60	20.50	89.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.40	84.50	3.90	95.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	103.90	0.00	103.90	0.0
210807	Газрын төлбөр	4.70	4.70	0.00	100.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23.80	15.80	8.00	66.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	48.30	22.40	25.90	46.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,470.00	205,313.13	-102,843.13	200.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,364.60	196,966.63	-105,602.03	215.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,105.40	8,346.50	2,758.90	75.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,052.70	57,706.10	1,346.60	97.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,052.70	57,706.10	1,346.60	97.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,626.00	12,626.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,424.10	29,077.50	1,346.60	95.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,561.70	12,561.70	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,440.90	3,440.90	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,185,429.20	712,773.12	472,656.08	60.1
220001	Барилга байгууламж	859,926.20	427,038.71	432,887.49	49.7
221001	Их засвар	75,403.00	144,699.78	-69,296.78	191.9
222001	Тоног төхөөрөмж	250,100.00	141,034.62	109,065.38	56.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,570.00	71,000.00	-430.00	100.6
230001	Эргэж төлөгдөх зээл	70,570.00	71,000.00	-430.00	100.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,803,698.80	3,328,724.89	474,973.91	87.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,570,406.80	1,515,034.48	55,372.32	96.5
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,570,406.80	1,515,034.48	55,372.32	96.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,079,134.80	1,734,509.82	344,624.98	83.4
320001	Орон нутгийн төсвөөс	1,920,768.60	1,576,143.62	344,624.98	82.1
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	158,366.20	158,366.20	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,178.30	17,551.68	7,626.62	69.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,178.30	17,551.68	7,626.62	69.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	128,978.90	61,628.92	67,349.99	47.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,300.00	61,558.92	-10,258.92	120.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	77,678.90	0.00		0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	80,665.52		0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	82,382.97		0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290,959.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,459.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,071.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,563.34
210102	Нэмэгдэл	35,849.21
210104	Урамшуулал	2,714.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,691.13
210201	Тэтгэврийн даатгал	3,619.30
210202	Тэтгэмжийн даатгал	268.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	214.86
210204	Ажилгүйдлийн даатгал	53.71
210205	Эрүүл мэндийн даатгал	534.69
2104	Хангамж, бараа материалын зардал	26,627.14
210401	Бичиг хэрэг	3,915.72
210402	Тээвэр, шатахуун	11,461.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	463.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	482.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,303.75
2105	Нормативт зардал	98,256.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,256.53
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	356.89
210601	Багаж, техник, хэрэгсэл	356.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,260.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,260.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,387.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,387.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,388.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,388.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,388.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	290,959.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,959.73
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,857.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,661.72
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,385.81
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,664.50
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	118,390.34
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн / цаашид Хүдэр сумын ТТЗ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төсвийн төлөвлөлтийг бодит тооцоог үндэслэн үнэн зөв төлөвлөх, төрийн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын төсвийг тухайн оны төсөвт тусгаж, олгож байх, төлбөрийн цахим баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг бүрэн хөтөлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ТТЗ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүдэр сумын ТТЗ-ийн эрхэм зорилго нь “Газар тариалан мал аж ахуйг тэргүүлэх салбараа болгож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, уул уурхайгаа түшиглэн, аялал жуулчлалыг хөгжүүлж байгалийн баялгийг зүй зохистой ашиглан өрхийн үйлдвэрлэлээ дэмжиж хүн амынхаа амар тайван элбэг хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино гэж тодорхойлжээ.

Хүдэр сумын ТТЗ нь тайлант онд дараах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал,

амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,354,980.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 50,324.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 37,743.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 769,392.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,641,266.9 мянган төгрөг болж, 871874.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дунд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	769,392.4	1,641,266.9	871874.5	53.1
Дүн	769,392.4	1,641,266.9	871,874.5	53.1

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ерөнхий орлогын 1,558,884.0 мянган төгрөг, СХС-ийн 13,711.8 мянган төгрөг, ОНХС-ийн 62,395.3 мянган төгрөг, ЭМТ-ийн харилцах дансны 6,275.8 мянган төгрөг тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ:

- Тайлант оны нэмэлт орлого буюу түргэвчилсэн төсвийн үнийн зөрүүгийн 5,563.0 мянган төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүйгээр тавилга эд хогшил / ширээ, сандал гэх мэт / худалдан авсан.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 180,263.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 206,229.0 мянган төгрөг болж, 25,965.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7,009.7	9,813.1	2,803.4
Байгууллагаас авах авлага	-	23,080.3	23,080.3
Татаас, санхүүжилтийн авлага	6,225.6	3,788.0	(2,437.6)
Зээлийн хүүгийн авлага	9,160.8	7,652.1	(1,508.7)
Хувь хүмүүсээс авах авлага	6,699.5	6,699.5	-
Зээлийн авлага	151,167.9	155,196.0	4,028.1
Дүн	180,263.5	206,229.0	25,965.5

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлага 25,965.5 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагчидтай холбогдсон авлага 2,803.4 мянган төгрөг, СХС-аас олгосон зээлийн авлага 4,028.1 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 23,080.3 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /нийт/ 22,495.0 мянган төгрөгийн СХС-ийн зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар шүүхэд 6 зээлдэгчийн материалыг хүргүүлж, ШШГГ-аас 3 зээлдэгчийн зээл хуваарийн дагуу төлөгдөж байна.

Тайлант онд монгол банкны хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийн санд мэдээллийг бүрэн шивж оруулснаар зээлийн эргэн төлөлт сайжирч, СХС-ийн зээлийн эргэлтийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас сумын төвд тавигдсан замын ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид давхардуулан шилжүүлж, 18,314.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 117,726.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 192,602.5 мянган төгрөг болж, 74,875.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
35130	Эм боох материал	22,809.1	30,772.8	7,963.7
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,628.6	0.0	-1,628.6
35410	Бичиг хэргийн материал	780.0	2,001.0	1,221.0

35420	Аж ахуйн материал	39,803.8	82,939.4	43,135.6
35430	Сэлбэг хэрэгсэл	5,900.5	5,900.5	0.0
35460	Хүнсний материал	4,108.0	1,361.8	-2,746.2
35470	Бусад хангамжийн материал	42,036.8	68,967.0	26,930.3
35600	Мал амьтад	660.0	660.0	4317123.98
	Дүн	117,726.8	192,602.5	74,875.7

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 650,266.2 мянган төгрөгийн материалыг төсвийн хөрөнгөөр, 45,795.8 мянган төгрөгийн материалыг хандиваар, 134,422.8 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, 689,895.4 мянган төгрөгийн материал зарцуулж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 65,713.7 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 74,875.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдлүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ:

- Ковидын хандивын зарцуулалтын тайланг зардлын төрлөөр нь зарцуулсан тухай бүрд тайлагналгүй оны эцэст бөөн дүнгээр тайлагнаснаас 1,276.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусад хангамжийн материалд бүртгэж бүртгэл тайланд тусгасан.

ЕБС:

- ЕБС нь хүнсний материалын худалдан авалтыг гэрээнд санал болгосон үнийн дүнгээс 8-10 хувиар нэмэгдүүлж нийт 2,009.6 мянган төгрөгийн барааг нэмэлт гэрээ хийгээгүйгээр худалдан авалт хийсэн

Цэцэрлэг:

- Цэцэрлэг нь Хүнсний материалын худалдан авалтыг 11 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дээр түүвэрлэж үзэхэд гэрээнд санал болгосон үнийн дүнгээс 8-10 хувиар нэмэгдүүлэн худалдан авсан боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 6,253.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 52,265.8 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 4,328.8 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 26828,5.4 мянган төгрөгийн,

- ЕБС нь 36,436.6 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг нь 13,568.4 мянган төгрөгийн

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **7,025,930.57** мянган төгрөг байсан бол оны эцсийн үлдэгдэл **8,007,125.95** мянган төгрөг болж, **981,195.4** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,861,321.90	5,142,131.51	280,809.6
Авто-тээврийн хэрэгсэл	446,470.10	436,907.60	(9,562.5)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	391,455.95	425,468.65	34,012.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	229,290.39	225,788.35	(3,502.0)
Зам, гүүр байгууламж	437,610.59	851,042.31	413,431.7
Бусад үндсэн хөрөнгө	520,203.98	806,683.28	286,479.3
Дуусаагүй барилга, байгууламж	27,431.30	27,431.30	-
Ном	42,888.55	33,013.16	(9,875.4)
Программ хангамж	1,859.00	1,859.00	-
Бусад биет бус хөрөнгө/Газар/	67,148.80	56,550.80	(10,598.0)
ДҮН	7,025,930.57	8,007,125.95	981,195.4

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд /анхны өртгөөр/ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЕБС-ийн 543,632.2 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулан бүртгэж, төсвийн хөрөнгөөр 451,857.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, иргэд аж ахуйн нэгжээс 46,898.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар, 65,000.0 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 100,000.0 мянган төгрөгийн зорь, сумын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 151,599.8 мянган төгрөгийн цахим худаг, цэцэрлэгт хүрээлэн зэргийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, аймгийн ИТХ-ын 2021 оны 34 дүгээр тогтоолоор сумын ЭМТ-ийн 275,374.6 мянган төгрөгийн хуучин барилга, байгууламж, газрыг Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газрын Хүдэр сум дахь аврах салбарт шилжүүлэн, сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний 37 дугаар тогтоолоор 102,418.0 мянган төгрөгийн ном сурах бичиг, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж үндсэн хөрөнгийн данснаас хасаж бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 420,000.0 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа, гүүр, цэцэрлэгт хүрээлэн, цахим худаг, замын тэмдэг тэмдэглэгээ зэрэг хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөд бүртгэснийг залруулж зам гүүрний байгууламжийн дансанд бүртгэсэн,

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 65,000.0 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашааг орлогоор бүртгэж, тайланд тусгуулсан,
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийн дүн үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдлээс 52,150.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлаар тайлагнах 99,686.1 мянган төгрөгийн зарцуулалтыг урсгал зардлын бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 9,107.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 8,459.0 мянган төгрөг болж, 648.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Өр төлбөр

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	107.5	4,480.3	4,372.8
Байгууллагад төлөх өглөг	9,000.0	3,978.7	(5,021.3)
Дүн	9,107.5	8,459.0	(648.5)

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМТ-ийн ажилчдад олгох илүү цагийн цалин, НДШ-ийн 4,480.3 мянган төгрөг, оны эцэст төсөвт төвлөрүүлсэн 3,978.7 мянган төгрөг зэрэг нийт 8,459.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ :

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 810.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,938,995.3 мянган төгрөг байсан бол 8,676,331.62 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,737,984.77 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,019,840.12	1,019,840.12	
Хуримтлагдсан үр дүн	2,547,972.56	4,285,957.33	1,737,336.29
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,362,075.17	3,362,075.17	
Дүн	6,938,995.33	8,676,331.62	1,737,336.29

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд ЗДТГ-т 70.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 61,558.9 мянган төгрөг зэрэг нийт 61,628.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **88,192.1** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ:

- Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ИТХ-ын төсвийг 6,500.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын төсвийг 19,646.0 мянган төгрөгөөр, Соёлын төвийн төсвийг 10,000.0 мянган төгрөгөөр гэх мэт зардлыг 36,146 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, компьютер, тоног төхөөрөмж худалдан авч, урсгал засварт зарцуулсан,
- ИТХ-ын 2021 оны 31 дүгээр тогтоолоор СХС-аас олгох зээлийг 70,570.0 мянган төгрөгөөр баталсан боловч 71,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгож төсвийг 430.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,

ИТХ:

- Ажлын албаны автомашины 3,500.0 мянган төгрөгийн сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй

ЗДТГ:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,412.3 мянган төгрөгийн цалингийн зардлаас төлөгдөх шимтгэлийг НДШ-ийн зардлаас төлж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.
- Батлагдсан төсвөөс урсгал засварын зардлыг 1,162.2 мянган төгрөгөөр, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 1,629.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн зарцуулсан.
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төсөвлөж тайлагнаагүйгээс сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 14,100 мянган төгрөгийн "Байгууллагуудын гоёлын гэрлийн ажил"-ын 8,600.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардлын барилга байгууламж зардалд, 5,500.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмжийн зардлаар хувааж бүртгэсэн.

- Төрийн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын төсвийг тухайн оны төсөвт тусгаж батлуулаагүйгээс үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгодоггүй,
- Ажлын албаны автомашины 7,510.0 мянга төгрөгийн сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй

ЕБС:

- Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр Б.Дэлгэрцэцэгийн цалингийн шатлалыг ахиулж 154.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон,

Цэцэрлэг :

- Эмч Б.Энхбат, нягтлан бодогч З.Шинэхүү нарт ажил хавсран гүйцэтгэж буй цалингаас ТАХ-ны нэмэгдэлд 122.2 мянган төгрөгийг олгосон,

Соёлын төв:

- Үйлчлэгч Д.Оюунд өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг үндсэн цалингийн дунджаар бус батлагдсан төсвийн дүнгээр тооцон 925.9 мянган төгрөг илүү олгосон.

ЭМТ:

- Ажлын албаны автомашины 7,000.0 мянган төгрөгийн сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөвт батлах тухай” 18 дугаар тогтоолоор татварын орлогын 530,400.7 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 75,000.0 мянган төгрөгөөр, нийт орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 605,400.7 мянган төгрөгөөр баталсан боловч сумын ИТХ-ын 8 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тогтоолоор татварын орлогыг 1,080,400.7 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 75,000.0 мянган төгрөгөөр, нийт орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,155,400.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр 2,283,060.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1,127,660.1 мянган төгрөгөөр буюу 1,9 дахин давуулан биелүүлсэн байна.

СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Төсвийн татварын орлого	1,080,400.70	1,973,875.20	893,474.50	182.7
2	Үйл ажиллагааны орлого	10,000.00	14,526.43	4,526.43	145.3
3	Хөрөнгийн орлого	2,600.00	19,868.74	17,268.74	764.2
4	Хөрөнгө борлуулсны орлого	700.00	10,544.05	9,844.05	1,506.3
5	Бууны албан татвар	3,360.00	2,752.00	(608.00)	81.9
	Малд ногдуулах албан татвар	-	32,535.40	32,535.40	
6	Улсын тэмдэгтийн хураамж	4,000.00	74,290.42	70,290.42	1,857.3
7	Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	1,000.00	758.67	(241.33)	75.9
8	Хог хаягдал үйлчилгээ	2,000.00	3,119.40	1,119.40	156.0
9	Газрын төлбөр	76,400.00	109,135.02	32,735.02	142.8
10	Ойн нөөц ашигласны төлбөр	162,106.70	313,966.88	151,860.18	193.7
11	Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,634.00	1,350.00	(1,284.00)	51.3
12	Байгалийн ургамал ашигласны төлбөр	815,600.00	1,391,028.19	575,428.19	170.6
13	Бусад орлого	30,000.00	290,760.80	260,760.80	969.2
14	Хүүгийн орлого	45,000.00	18,424.81	(26,575.19)	40.9
	Нийт орлого	1,155,400.70	2,283,060.80	1,127,660.10	197.6

Төсвийн орлогын төлөвлөгөө 1,9 дахин давж биелэхэд үйл ажиллагааны орлого 4,526.4 мянган төгрөг, хөрөнгийн орлого 17,268.7 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 9,844.0 мянган төгрөг, малд ногдуулах албан татвар 32,535.4 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 70,290.4 мянган төгрөг, газрын төлбөр 32,735.0 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 151,860.2 мянган төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 575,428.2 мянган төгрөг, бусад орлого 260,760.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Үйл ажиллагааны орлого:** Тайлант жилд тариаланчдад олгосон улаан буудайн урамшуулал, малчдад олгосон сүү, ноос, ноолуурын урамшууллаас суутгасан орлогын албан татвараас шалтгаалан орлого 4,526,4 мянган төгрөгөөр,
- **Малын татвар:** Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжсэнээр төлөвлөгөөнд тусгагдаагүй 32,535.4 мянган төгрөгийн орлого төвлөрсөн.
- **Хөрөнгийн албан татвар:** Банкны хадгаламжийн хүүгийн орлогыг аймгийн төсөвт бус тухайн сумын орон нутгийн орлогот төвлөрүүлсэнтэй холбоотойгоор 17,268.74 мянган төгрөгөөр,

- **Хөрөнгө борлуулсны орлого:** Худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгө нэмэгдсэн тул орлого 9,844.05 мянган төгрөгөөр,
- **Улсын тэмдэгтийн хураамж:** Байгалийн ургамал ашигласны гарал үүслийн бичилтийн улсын тэмдэгтийн хураамж 70,290.42 мянган төгрөгөөр,
- **Газрын төлбөр:** Дархан төмөрлөгийн уурхайн 2019, 2020 онуудын газрын төлбөр төлөгдсөнөөр 32,735.02 мянган төгрөгөөр,
- **Ойн нөөц ашигласны төлбөр :** Хэрэглээний мод бэлтгэх зөвшөөрөл нэмэгдэж батлагдсанаас мод бэлтгэх эрхийн бичгийн орлого 151,860.1 мянган төгрөгөөр,
- **Байгалийн ургамал ашигласны татвар:** Самрын ургац өндөр тогтоогдож эрхийн бичгийн орлого 575,428.19 мянган төгрөгөөр.
- **Бусад орлого:** Хураагдсан модны дуудлага худалдааны орлого 260,760.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Хүүгийн орлого:** Газрын төлбөрийн орлого 26,575.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 3,899,369.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор төсвийн орлого 605,400.7 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих орлого 605,916.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 154,451.9 мянган төгрөг, ОНХС-аас олгох санхүүжилт 158,366.2 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 56,108.9 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт 1,615,083.8 мянган төгрөг, СХС-ийн орлогыг 51,300.0 мянган төгрөгөөр, өмнөх оны үлдэгдлээс 21,570.0 мянган төгрөг, зэрэг нийт 3,268,197.5 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан аймгийн Засаг даргаас хүргүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 23-ны 01/768 дугаар “2021 оны тодотгосон төсөв хүргүүлэх тухай” албан бичгийг үндэслэн тусгай шилжүүлгийн байгууллагын төсөвт өөрчлөлт оруулан тодотгол хийсэн байна.

Сумын ИТХ нь “Хүдэр сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тогтоолоор татварын орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан нийт орлогыг нэмэгдүүлэн 1,155,400.7 мянган төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг 27,071.9 мянган төгрөгөөр бууруулж 1,588,011.9 мянган төгрөгөөр, СХС-ийн зардлыг 72,870.0 мянган төгрөгөөр, зэрэг нийт орлого, зарлагыг тус бүр 3,791,125.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Үүнээс ТШ-ийн байгууллагуудад 1,588,011.9 мянган төгрөг, ИТХ-д 82,219.7 мянган төгрөг, ЗДТГ-т 415,743.4 мянган төгрөг, ЗДН-д 60,900.0 мянган төгрөг, СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

Соёлын төвд 124,741.1 мянган төгрөг, ОНХС-д 214,475.1 мянган төгрөг, байгаль хамгаалах үйл ажиллагаа, хог хаягдал, ахмад настны дэмжлэгт 20,793.6 мянган төгрөг, ТШБ-ийн тогтмол зардалд 240,416.9 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтад 970,954.0 мянган төгрөг, СХС-ийн зардлыг 72,870.0 мянган төгрөг, зэрэг нийт **3,791,125.6** мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Төсвийн тодотгол

2021 оны 35 дугаар тогтоолоор сумын ИТХ-ын зардлыг 6,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 82,219.7 мянган төгрөг, ЗДН хөрөнгийн зардлыг 35,900.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 60,900.0 мянган төгрөг, ЗДТГ-ын зардлыг 19,646.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 415,743.4 мянган төгрөг, Соёлын төвийн зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 124,741.1 мянган төгрөг, нийт орон нутгийн байгууллагын урсгал зардлыг **72,046.0** мянган төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг **477,954.0** мянган төгрөгөөр, ЕБС-ийн зардлыг 52,684.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, 1-р цэцэрлэгийн зардлыг 79,756.3 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар ТЗШ-ийн байгууллагад олгох санхүүгийн дэмжлэгийг 12,573.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн тул нийт зарлагын төлөвлөгөө **3,803,698.8** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан нийт **3,327,007.4** мянган төгрөг, үүнээс 2,543,234.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 712,773.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн эргэн төлөгдөх зээлд 71,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр ТШБ-уудын санхүүжилт 1,570,406.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,576,143.6 мянган төгрөг, ОНХС-аас 158,366.2 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 61,628.9 мянган төгрөг, ЭМ-ийн даатгалын сангаас 17,551.7 мянган төгрөг, зэрэг нийт **3,384,097.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,327,007.4 мянган төгрөг буюу 87.5 хувьтай тайлагнагдсан нь орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 712,773.3 мянган төгрөг буюу 60.1 хувь, ТШБ-уудын санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нийт 54,039.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 21,990.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 5,185.0 мянган төгрөгөөр, нормативд зардал 18,791.4 мянган төгрөгөөр, томилолтын зардал 2,320.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал 6,425.9 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардал 1,346.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 472,656.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, багаж техник хэрэгсэл худалдан авах СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

зардлыг 1,629.4 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,162.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх зээлийг 430.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 5 төсөл, арга хэмжээнд 214,475.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, 4 төсөл арга хэмжээнд 152,080.0 мянган төгрөг зарцуулж, 1 төсөл арга хэмжээний 62,395.1 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 68,385.8 мянган төгрөг, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 24,661.7 мянган төгрөг, хандив 34,857.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 44,664.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон 118,390.3 мянган төгрөг, нийт 290,959.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнд:

- ЗДТГ-т ковид-19 цар тахлын үед иргэн аж ахуйн нэгжээс хандивласан 29,374.3 мянган төгрөг,
- ЭМТ-д ковид-19 цар тахлын үед иргэн аж ахуйн нэгжээс хандивласан 5,483.0 мянган төгрөг,
- Хүүхэд хөгжлийн газраас сумын хамтарсан багт 300.0 мянган төгрөг,
- Замын сангаас зам засварын санхүүжилт 32,500.0 мянган төгрөг,
- Статистикийн хэлтсээс хагас бүтэн жилийн мал тооллогын зардалд 3,314.4 мянган төгрөг,
- ЕБС-дад “Боловсролын шинэчлэл” төслийн санхүүжилт 8,514.0 мянган төгрөг,
- СӨБ-д ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 243.0 мянган төгрөг,
- ЭМТ-д ковид-19 цар тахлын үед ажилсан эмч эмнэлгийн ажилчдад олгох нэг удаагийн буцалгүй тэтгэмжийн санхүүжилт 38,658.0 мянган төгрөг,
- Урьд оны татан төвлөрүүлсэн орлогын буцаан олголт 3,115.0 мянган төгрөг,
- ЭМТ-ийн эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлого 41,549.5 мянган төгрөг,
- ЕБС-ийн түрээсийн номын орлого 4,588.0 мянган төгрөг,
- Улсын төсвөөс олгосон усны түгээгүүрийн цэгийн усны орлого 4,930.2 мянган төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМТ-д эмийн үнийн хөнгөлөлт болон ковидын вакцинжуулалт, ковид туссан иргэдийн багц эмийн санхүүжилтэд 118,390.3 мянган төгрөг,

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 38,563.3 мянган төгрөг, НДШ-д 4,691.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 26,627.1 мянган төгрөг, нормативт зардалд 98,256.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 10,285.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 29,260.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 54,387.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 25,388.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 3,788.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 ажлыг гүйцэтгүүлэхээр 493,000.0 мянган төгрөг баталсан бөгөөд 2021 оны 35 дугаар тогтоолоор нэмж 15 ажлыг санхүүжүүлэхээр 477,954.1 мянган төгрөгийг тодотгон, нийт хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 970,954.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр 12 ажлын 660,539.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерийн баримт бичгийн бүрдэл дутуугаас 2014 онд ЗДТГ-ын дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэгдсэн 9,000.0 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн ажил, 18,431.2 мянган төгрөгийн зам гүүрний ажил, нийт 27,431.2 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгээгүй, ашигласан жилүүдийн элэгдэл тооцоогүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Хүдэр сумын ТТЗ-ийн мэдээлбэл зохих 155 мэдээллээс 119 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. ИТХ нь мэдээлбэл зохих 119 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож хугацаа хоцроож мэдээлсэн.

3. Сумын ЗДТГ нь мэдээлбэл зохих 119 мэдээллээс 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

4. ЭМТ нь мэдээлбэл зохих 119 мэдээллээс 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

5. Соёлын төв мэдээлбэл зохих 119 мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Хүдэр сумын ТТЗ-ийн тайлант оны урсгал үйл ажиллагаанд 2,547,699.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,543,234.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.2 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 82,219.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 82,223.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг хэмнээгүй,
- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 497,436.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 491,659.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.1 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаа 124,741.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 119,771.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4 хувиар хэмнэсэн,

Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 533.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 21,307.4 мянган төгрөгийн 9 албан шаардлага, 30,277.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	533.4	1	533.4			100
Албан шаардлага	9	21,307.4	8	21,307.4	1		88.8
Зөвлөмж	4	30,277.6	3	2,227.6	1	28,050.0	75
Нийт	14	52,118.4	12	49,827.1	2	28,050.0	87.8

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Хүдэр сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төсөвт тодотгол хийж, тоног төхөөрөмж худалдан авах болон урсгал засварын зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6, орон нутгийн төсөл сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бие даасан дүгнэлт гарсан 2, аудитын түүвэрт 4 байгууллага, 2 тусгай сангийн тайлан түүвэрт хамрагдсан байна.

Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 862,982.6 мянган төгрөгийн 24 алдаа, зөрчил илрүүлснээс 636,836.1 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1202.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 48,967.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 8 зөрчилд албан шаардлага, 175,076.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан 2 ерөнхий боловсролын сургууль болон 1 цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 810,691.7 мянган төгрөгийн 16 алдаа зөрчил илрүүлснээс 636,836.1 мянган төгрөгийн 4 зөрчлийг аудитын явцад залруулж, 925.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 49,867.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 албан шаардлага хүргүүлэн, 123,062.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмжийг хүргүүллээ.



4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 636,836.1 мянган төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

ЗДТГ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 420,000.0 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа, гүүр, цэцэрлэгт хүрээлэн, цахим худаг, замын тэмдэг тэмдэглэгээ зэрэг хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөнд бүртгэснийг, зам гүүрний байгууламжийн дансанд бүртгэсэн,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 65,000.0 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашааг орлогоор бүртгэж тайланд тусгуулсан,
- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдлээс 52,150.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлаар тайлагнах 99,686.1 мянган төгрөгийн зарцуулалтыг урсгал зардлын бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан.

4.2 Төлбөрийн акт

1. Соёлын төвийн үйлчлэгч Д.Оюунд өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг үндсэн цалингийн дунджаар бус батлагдсан төсвөөр тооцон 925.9 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 2.1 дэх "Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно" гэсэн заалтыг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ИТХ-ын төсвийг 3,000.0 мянган төгрөгөөр /суурин компьютер, принтер, шагнал урамшуулал/, ЗДТГ-ын төсвийг 7,546.0 мянган төгрөгөөр /компьютер, өнгөт принтер/, Соёлын төвийн төсвийг 10,000.0 мянган төгрөгөөр /тайз хийх/ зэрэг нийт урсгал зардлыг **20,546.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь "Засаг дарга дараах СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, 63,0төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 810.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, сумын төвд тавигдсан замын ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид давхардуулан шилжүүлж, 18,314.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог хянан баталгаажуулах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,412.3 мянган төгрөгийн цалингийн зардлаас төлөгдөх шимтгэлийг НДШ-ын зардлаас төлж зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4. ЗДТГ нь батлагдсан төсвөөс урсгал засварын зардлыг 1,162.2 мянган төгрөгөөр, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 1,629.4 мянган төгрөгөөр, нийт 2,791.6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, зайлшгүй тохиолдолд ИТХ-д өргөн мэдүүлж, шийдвэрлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

5. ИТХ-ын 2021 оны 31 дүгээр тогтоолоор СХС-аас олгох зээлийг 70,570.0 мянган төгрөгөөр баталсан боловч 71,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгож төсвийг 430.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь *“Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, зайлшгүй тохиолдолд ИТХ-д өргөн мэдүүлж, шийдвэрлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

6. ЭМТ нь тайлант оны нэмэлт орлого буюу түргэвчилсэн төсвийн үнийн зөрүүгийн 5,563.0 мянган төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүй тавилга эд хогшил худалдан авах зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь *“Төсвийн байгууллага төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.”*, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх *“Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”*, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”*-ын 2.6, 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 1.4, 4.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны нэмэлт орлогыг төрийн сан дахь бүртгэлийн дансанд тухай бүр төвлөрүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах албан шаардлага хүргүүлэх.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 14,100 мянган төгрөгийн өртөг бүхий *“Байгууллагуудын гоёлын гэрлийн ажил”*-ын төсөл, арга хэмжээг 2 хувааж буюу 8,600.0 мянган төгрөгийг хөрөнгийн барилга байгууламж зардлын ангилалд, 5,500.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмжийн зардлын ангилалд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Үнэлгээ ба хуваарилалт”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн зардлыг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв ангилан, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: ЗДТГ нь төрийн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн оны төсөвт тусгаж батлуулаагүйгээс албан хаагчдын ажлын үр дүнг улирлаар үнэлж, мөнгөн урамшуулал олгоогүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.3-д “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Урамшууллын зардлыг төсөвт тусган батлуулж, олгож байх.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: ИТХ нь 3,500.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 7,510.0 мянга төгрөгийн, ЭМТ нь 7,000.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601-2011 стандартыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж, урсгал болон их засвар, нийт км, шатахуун зарцуулалтуудын тооцоог бүрэн бүртгэн, хяналтыг сайжруулах.

3.2.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 6,253.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 52,265.8 мянган төгрөгийн, Соёлын төв нь 4,328.8 мянган төгрөгийн, ЭМТ нь 26,828.5 мянган төгрөгийн зэрэг нийт 89,676.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн

заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4.1 Илрүүлэлт: ЗДТГ нь ковидын хандивын зарцуулалтын тайланг зардлын төрлөөр нь зарцуулсан тухай бүрд тайлагналгүйгээр оны эцэст бөөн дүнгээр тайлагнаснаас 1,276.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусад хангамжийн материалд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Ангилал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв ангилан бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс				Зөвлөмж	
				᠑	Дүн	Залруулга	Акт	Албан шаардлага	Хариуцлага тооцоо х		
				᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td></td></td></td></td></td>	Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td></td></td></td></td>	᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td></td></td></td>	Дүн <td>᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td></td></td>	᠑ <td>Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td></td>	Дүн <td>᠑ <td>Дүн</td> </td>	᠑ <td>Дүн</td>	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар											
1	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн замыг бусад үндсэн хөрөнгөд бүртгэснийг зам гүүрний байгууламжийн дансанд бүртгүүлсэн.	1	420,000.00	1	420,000.00				
2	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тариалангийн талбайн хашааг санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй байсан.	1	65,000.00	1	65,000.00				
3	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ -ын санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан	1	52,150.00	1	52,150.00				

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлаар тайлагнах зарцуулалтыг урсгал зардлын бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан байна.	1	99,686.10	1	99,686.10											
5	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	Соёлын төвийн үйлчлэгч Д.Оюунд нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосон.	1	925.90	1	925.9											
6	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн тодотгол хийж, урсгал зардлыг нэмэгдүүлсэн.	1	20,546.0	1	20,546.0							1	20,546.0			
7	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь ХХОАТ-ын өглөг, сумын төвд тавигдсан замын ажлын санхүүжилтийг давхардуулан шилжүүлж авлага үүсгэсэн байна.	1	19,124.70	1	19,124.70							1	19,124.70			
8	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1	1,412.30	1	1,412.30							1	1,412.30			
9	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь урсгал засварын зардал болон багаж техник хэрэгсэл худалдан авах зардлын батлагдсан төсвийг хэтрүүлсэн зарцуулсан	1	2,791.60	1	2,791.60							1	2,791.60			

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь ковидын хандиваас зарцуулсан шатахууны зардлыг бусад хангамжийн материалд бүртгэж тайлагнасан.	1	1,276.00												1	1,276.0
11	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	СХС-аас олгох эргэн төлөгдөх зээлийн олголтын төсвийг 430.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн	1	430.00												1	430.00
12	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь тайлант оны нэмэлт орлого буюу түргэвчилсэн төстийн үнийн зөрүүгийн орлогоор тавилга эд хогшил худалдан авсан.	1	5,563.00												1	5,563.00
13	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг ангилал буруу бүртгэж, тайлагнасан	1	14,100.00												1	14,100.00
14	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь улирлын ажлын мөнгөн урамшууллын зардлыг төсөвт тусгадаггүй, урамшуулал олгодоггүй байна.	1													1	
15	ТТЗ	СЭА-2022/14-НА-СТА-ТТЗ	ИТХ, ЗДТГ ЭМТ-ийн автомашины сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, баталгаажуулаагүй.	1	18,010.00												1	18,010.00

